


ОЮУ ТОЛГОЙН ТУХАЙ ТОВЧХОН



■ Оюу Толгой нь Монгол Улсын өмнөд хэсэг, Өмнөговь аймагт нийслэл Улаанбаатар хотоос 600 километр зайд орших дэлхийн хамгийн том ашиглалтад бэлтгэж буй алт, зэсийн орд юм.

■ Оюу Толгойн олборлолт 2012 онд ил уурхайгаас эхлэх бөгөөд жилд 450,000 тонн зэс, 330,000 унц алт үйлдвэрлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна. Ингэснээр дэлхийн томоохон зэс, алтны уурхайн нэг болно.

■ Оюу Толгой нь Монгол Улсын Засгийн газар, Айвенхоу Майнз болон Рио Тинто группын хамтарсан компани юм. Энэхүү төслийг Рио Тинто 2010 оны 10 дугаар сараас удирдаж эхэлсэн бөгөөд тус компани нь Айвенхоу Майнзын хувьцааны 48,5%-ийг эзэмшдэг.



Хаягдал өтгөрүүлэгч байгууламж




БАРИМТЫН ТОВЧООН



ДЭД БҮТЦИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

- Оюу Толгой нь олон улсын стандартын нисэх буудал, 70 километр урт усны хоолой болон Монгол-Хятадын хил хүртэл 100 километр хатуу хучилттай зам, 220 кв хүчин чадал бүхий цахилгаан дамжуулах шугамыг бүтээн босгож байна.
- Өмнөговийн ард иргэдийн түвшинд, хүн амын эрүүл чийрэг аж төрөх хэвшлийг дэмжих зорилгоор Даланзадгад хотод бүсийн соёл, спортын цогцолбор барихад 2 сая ам.доллар, Баян-Овоо сумын спорт танхим барьж байгуулахад 600,000 ам.долларын хөрөнгө оруулалт хийж байна.



Оюу Толгой ХХК
Моннис цамхаг
Чингисийн өргөн чөлөө-15
Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар - 14240

Олон нийттэй харилцах хэлтэс
Утас: +976 11 331880
Факс: +976 11 331893
И-мэйл: OTLLCinfo@ot.mn
www.ot.mn